

## ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Түүх, соёл өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт
11. Хавсралт 01 - Түүхий эдийн шинжилгээний хариу
12. Хавсралт 02 - Бетон зуурмагийн шинжилгээний хариу
13. Хавсралт 03 - Хөрс, ус, агаарын шинжилгээний хариу
14. Хавсралт 04 - Төлбөр төлсөн баримтууд

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл:

Төсөл хэрэгжүүлэгч	“Рокмон”ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9011245080 Регистрийн дугаар: 2078228
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	210628 Улаанбаатар хот, Ш/Х-162, Баянгол дүүрэг, 2-р хороо, Үндсэн хуулийн гудамж-24, “Рокмон бюлдинг” өөрийн байранд. Утас: 976-11-325-333 Вэбсайт: <a href="http://www.rokmon.mn">www.rokmon.mn</a>
Төслийн байршил	Нийслэлийн Засаг даргын 2014 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/643 тоот шийдвэрээр 133038/0129 18664299101440 дугаар нэгж талбар бүхий 5га газрыг Баянзүрх дүүргийн 11-р хороо, Цэргийн холбооны сургуулийн баруун талд үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байна.
Төслийн нэр, хүчин чадал	Бетон зуурмагийн үйлдвэр. Тус бетон зуурмагийн үйлдвэр нь БНХАУ-ын HZS-150 загварын тоног төхөөрөмж ба M100-M500 маркийн бетон зуурмагийг цагт 150м.куб үйлдвэрлэх хүчин чадалтай.
Төслийн хугацаа	Бетон зуурмагийн үйлдвэр төсөл нь 2014 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн. Улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлдэг тул 4 дүгээр сараас 10 дүгээр сар дуустал жилд долоон сарын хугацаатай ажилладаг.

Төслийн талбайн ерөнхий байршил:



Төсөл хэрэгжихээс өмнөх үеийн талбайн байдал:



Төслийн талбайн өнөөгийн байдал:





Төслийн талбайн зохион байгуулалт:



Үйлдвэрээс төв зам хүртэлх автозам



100тн даац бүхий автопүү



150м<sup>3</sup>/цаг бетон үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр



Оффис, ажилчдын амралтын байр, цайныгазар



Лаборатори, диспетчер, харуулын ажлын байр



КТП



## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ нь үйлдвэрлэлийн бүхий л үйл ажиллагааны явцад гарч болзошгүй хүн, байгальд хортой сөрөг нөлөөллүүдийг илрүүлэн тогтооход оршино. “Эхмонголын байгаль” ХХК нь “Рокмон” ХХК-ийн өөрийн эзэмшлийн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Бетон зуурмагийн үйлдвэр”-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед Байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй нөлөөллийн үнэлгээг одоо хэрэглэгдэж байгаа “Магадлан жагсаах арга”, “Матрицын арга”-аар голлох нөлөөллийг тодруулах аргачлалыг ашиглан гаргасан. Үүнд тухайн төсөл хэрэгжих явцад байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулсан болно.

Шууд нөлөөлөл: Агаарын бохирдлын цэгэн үүсвэр бий болох, машин техник, хүний хөдөлгөөнөөр хатуу шингэн хог хаягдал нэмэгдэх, шатах тослох материалын хадгалалт хэрэглээнээс үүсэх химийн бодисын бохирдол зэрэг сөрөг нөлөөлөлтэй. Нөгөө талаас хувийн өмчийн болон татварын орлого, орон нутгийн орлого нэмэгдэх, ажлын байр, улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх эерэг нөлөөлөлтэй.

Шууд бус нөлөөлөл: Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үйлдвэрийн тоног төхөөрөмж бусад машин техникийн чимээ шуугиан ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх, болгоомжгүй үйлдлээс шалтгаалан гал түймэр гарах магадлалтай.

Удаан хугацааны нөлөөлөл: Хатуу, шингэн хог хаягдлыг хадгалах байгууламжийг тогтоосон дүрэм, журмын дагуу хийгээгүй, мөн ил задгай асгарах химийн нэмэлт бодис болон шатахуун түгээх цэгийн шатахуун, автомашины тос, тослох материал хөрсөнд шингэх зэрэг зохисгүй үйлдлүүдээс шалтгаалан хөрсөөр дамжин гүний усны чанар өөрчлөгдөх муудах, хөрс агаар бохирдох асуудал гарч болзошгүй бөгөөд эдгээр нь эргэж сэргэхдээ ихээхэн хугацаа шаарддаг.

Богино хугацааны нөлөөлөл: Үйлдвэрлэлийн явцад үүсэх шуу шуугианы нөлөө, машин механикмын үйлчлэлээр байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл бий болох, хөрс, ургамлын талхагдал, хөрсний элэгдэл эвдрэл гэх мэт богино хугацаанд үүсэх сөрөг нөлөөлөл байна. Үүний зэрэгцээ хувийн секторын болон татварын орлого нэмэгдэх, орон нутгийн төсвийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэг эерэг үзүүлтүүд бас байна.

Хүчтэй нөлөөлөл: Химийн нэмэлт бодис, шатахуун, тос, тослох материалуудын хөрсөнд үзүүлэх нөлөө, машин механикмын үйлчлэлээр байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл, машин техникийн ажиллагааны улмаас агаар хорт хийгээр бохирдох, тоосжилт ихээр үүсэх, болгоомжгүйгээс гал түймэр гарах, хүчтэй буюу аадар борооны улмаас үерт өртөх гэсэн хүчтэй нөлөөллүүд байна.

Дунд зэргийн нөлөөлөл: Машин механизмын үйлчлэлээр байгаль орчинд агаарын бохирдолтонд үзүүлэх нөлөөлөл энд хамаарна.

Сулавтар буюу бага эрчимтэй нөлөөлөл: Энэ нөлөөлөлд чимээ шуугианы улмаас ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, хатуу шингэн хог хаягдал ихсэх гэсэн асуудал хамаарна.

Үйлдвэрийн байршил нь Улаанбаатар хотоос алслагдсан Баянзүрх дүүрэг, 11-р хороонд, радио дамжуулах станцаас 800м зайд байрлаж байна. Хүн амын суурьшлын хэсгээс 800м зайтай, мөн тухайн бүс нутагт одоо барилга байгууламж барих үйл ажиллагаа идэвхитэй эхэлж байгаа болно. Иймд бүтээн байгуулалтын үйл ажиллагааны

улмаас хүнд даацын машин механизмын тээврийн нөлөөгөөр хөрсөн бүрхэвч эвдэгдэх, тоосжилтын нөлөө ихсэх хандлагатай байна.

Энэхүү бетон зуурмагийн үйлдвэр нь бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн хэрэглэгчдэд хүргэх арга технологи, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн автоматжилт зэрэг нь орчин үеийн техник, технологийн шаардлагыг бүрэн хангасан. Үйлдвэрлэлийн технологийн процессын явцад гарах тоос ба хорт хий, тоосжилт зэрэг нь агаарын чанарт багагүй нөлөөлөхөөр байгаа тул агаарын бохирдлыг бууруулах, үйлдвэрийн ахуйн хэрэгцээг сайжруулах зорилгоор “Байгаль хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу үйлдвэрийн барилга, зам талбайн зохион байгуулалтыг БНБД болон зохих стандартын шаардлагын дагуу үйлдвэрийн ил талбай болон үйлдвэрээс төв зам хүртэлх тээврийн замыг хатуу хучилттай болгон, үйлдвэрлэлийн бус талбайг анхны байдлаар хамгаалан хязгаарлаж, явган хүний хайрган замыг барьж тохижуулсан.

Мөн ажиллагсдын ажлын эрүүл ахуй, амралтын тав тух, ажлын хэвийн нөхцөлийг хангаж, оффисын байр, лаборатори, цайны газар, амралтын өрөө, бие засах газар, угаалгын өрөө /халуун хүйтэн устай/ зэргийг барьж ашиглалтанд оруулсан.

Ажлын байрны тоосжилт, дуу чимээ нь ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх магадлал өндөр тул жил бүр үйлдвэрийн нийт ажилтан ажиллагсдыг эрүүл мэндийн шинжилгээнд бүрэн хамруулах, хөдөлмөр хамгааллын хувцас, гутал, ажлын бээлий, амны хаалт зэргийг нормчлолын дагуу олгон ажиллаж байна.

### **Бетон зуурмагийн үйлдвэрийн гол сөрөг нөлөөлөл**

Болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзэхэд тус бетон зуурмагийн үйлдвэр нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ба үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг агаар, хөрс зэрэгт нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн, хөрсийг бохирдол, элэгдлээс хамгаалах, агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах, хамгаалах зэрэг арга хэмжээнүүдийг үнэлгээ хийсэн компанийн зүгээс өгсөн зөвлөмжийн дагуу тухай бүрт нь хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Үйлдвэрийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь үйлдвэрийн түүхий эдийн болон элс хайрганы хадгалалт, бункерт ковшоор зөөхөд үүсэх тоосжилт, үйлдвэрийн орчимд автомашинаас ялгарах агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр бий болох, автомашины тос тосолгооны материал хаягдах, хөрсийг автомашины тос тослох материалууд, химийн нэмэлт бодис, технологийн угаалгын ус хаягдлаар бохирдуулах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрэглэж буй гүний худгийн усыг зохисгүй хэрэглэснээс гүний усны нөөцөд нөлөөлөх зэрэг болно.

Голлох сөрөг нөлөөллийн чанарын үнэлгээний шалгуур

Төвшин	Зэрэг	Сөрөг нөлөөлөл	Тайлбар	Шийдэл
V	их	Түүхий эд буулгах үед болон хадгалалт, үйлдвэр лүү зөөж тээвэрлэх үед үйлдвэрийн талбайгаас үүсэх тоосжилт	Дунд зэргийн хохирол	- Зам талбайн усалгаа, - Түүхий эдийн талбайн хаалт хийх
III	дунд	Химийн нэмэлт бодис, автомашины болон үйлдвэрийн тос тосолгооны бодисын тархалт	Их хохирол	- Үйлдвэрийн удирдлага болон мэргэжлийн байгууллагын шийдэл
V	их	Бохирдсон хөрс болон усаар дамжин гүний ус бохирдох	Их хохирол	- Бохирдол үүсэхээс ямагт сэргийлж ажиллах - Шаардлагатай зам талбайг хатуу хучилттай болгох
III	дунд	Дуу чимээ, доргионы бохирдол	Хүний эрүүл мэнд	- Үйлдвэрийн шийдэл

Агаар орчны бохирдол

Үйлдвэрийн байршил нь Улаанбаатар хотын алслагдсан зүүн дүүрэгт байрладаг ба энэ байршил нь нийслэл хотын агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо болон нийслэлийн агаарын чанарын албанаас хамтран хэрэгжүүлж буй агаарын бохирдлыг бууруулах хязгаарлалтын бүсэд ордоггүй байна. Үйлдвэрийн агаарын бохирдлын голлох эх үүсвэрүүд нь цемент, үйлдвэрийн дүүргэгч түүхий эдүүдийн талбай болон үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй хүнд механизм, авто машинууд байна.

Тоос, тоосонцорын бохирдол

Үйлдвэрийн түүхий эдийн хүлээн авах, үйлдвэрлүү зөөх үед, мөн түүхий эд хадгалах талбайгаас ойр орчимдоо тодорхой хэмжээний тоосонцорын бохирдол үүсгэдэг. Үйлдвэрийн орчны автомашин болон хүний ажиллагааны нөлөөгөөр элэгдсэн газрын суларсан хөрс шороо нь салхи болон бусад механик хүчин зүйлийн нөлөөгөөр бохирдуулагч эх үүсвэр болдог.

**Сөрөг нөлөөллийг багасгах, арилгах зөвлөмж, түүний гүйцэтгэл**

Байгалийн баялгийг зохистой байдлаар ашиглан хамгаалах, байгаль орчиндоо сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аливаа нөлөөллийг бууруулан ажиллах нь аливаа бизнес эрхлэгч аж ахуй нэгжийн үндсэн үүрэг бөгөөд байгаль орчинд учруулсан аливаа хохирлын хариуцагч байна. “Рокмон” ХХК-ийн удирдлага өнгөрсөн жилд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үүсэх сөрөг нөлөөллийг багасгах арилгах зөвлөмжийн дагуу байгаль орчинд ээлтэй дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Агаарын бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээ, гүйцэтгэл:

- *Автомашины байнгын хөдөлгөөнтэй хэсгийн замыг хатуу хучилттай болгох нь тоосжилт болон хөрсний эвдрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой байна.*



“Ди Вай Кэй Би” ХХК-тай хамтран ШИФР 09/14 тоот батлагдсан зургийн дагуу үйлдвэрийн объектыг Улаанбаатар - Налайх чиглэлийн төв авто замтай холбосон 8 метр өргөн, 110 метр урт асфальт бетон зам талбайг барьж ашиглалтанд оруулсан.



- *Тоосжилт тархах хүрээ ачиж тээвэрлэх буулгах газраас 50-100м орчимд байхаар түүхий эдийн ачиж буулгах байршилыг оновчтой сонгох, улмаар барилга байгууламж болон байнгын ажлын байрнаас зайдуу байршуулах хэрэгтэй*

Үйлдвэрийн байнгын ажлын байр болох оффис, ажилчдын амралтын байр, цайны газар, лаборатори, харуулын байр, агуулах зэргээс түүхий эд ачих буулгах талбай нь 100м орчим зайд байрладаг.





- *Үйлдвэрийн үйл ажиллагаа, барилгажилт, зам талбайд өртөгдөхгүй талбайг зүлэгжүүлэх*

Үйлдвэрийн нийт талбай 5га бөгөөд бид энэхүү талбайн 40 хувьд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа явуулж байна. Үлдсэн талбайг анхны байдлаар хадгалан үлдээж, хязгаарлалт хийн, хамгаалалтанд авсан.



- *Үйлдвэрт дүүргэгч өгөх ковшийн замыг тоос бага гаргадаг материалаар өнгөлөх байнга усалж байх, ялангуяа тоосжилт шороон шуурганы дараа нэмэгддэг хуурайшилттай хаврын улиралд үйлдвэрийн талбайг усаар норгох, чийглэх, өвөл нь автогрейдрээр тэгшлэх орсон цасыг замын элстэй хольж тэгшлэн дагтруулах.*

Талбайд байрлах түүхий эдээс үйлдвэрийн хүлээн авах бункер хүртэлх ковшийн явах замыг хайрга дэвсэн дагтаршуулсан. Мөн усны нөөцийн ёмкость ахуйн хэрэглээний, үйлдвэрийн хэрэглээний гэсэн хоёр хэсэгт байна. Ахуйн хэрэглээний ёсность 500л багтаамжтай ба цайны газар, угаалгын газрын усны хэрэгцээнд зориулагдсан. Үйлдвэрийн усны нөөцийн 2 ширхэг сав нь тус бүр 50тн багтаамжтай ба энэ нь үйлдвэрлэлийн хэрэгцээг болон зам талбайн усжуулалтад хангалттай хүрэлцдэг. Харин үйлдвэрийн үйл ажиллагаа нь улирлын чанартай учир өвлийн улиралд ажилладаггүй болно.



- *Үйлдвэрийн талбайн хашааны эргэн тойронд салхи тоосноос хамгаалах ургамал, сөөглөг ойн зурвас байгуулах замаар салхины хурд хүчийг сааруулан, хөрсний өнгөн шороо тоос хийсэхийг багасгах бутлаг сөөглөг ургамлан төгөл, ойн зурвас байгуулахдаа тухайн нутаг дэвсгэрт тархсан суулгацыг тарих зэрэг арга хэмжээ авах.*

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа өргөжин тэлэх, барилга байгууламж барих зэрэг бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан ногоон байгууламжийг тухайн оны менежмент төлөвлөгөөндөө тусган ажиллах бодлогыг барин ажиллана. Одоогийн байдлаар үйлдвэрийн эргэн тойронд газрыг бүрэн ашиглаагүй үндсэн хөрсөөрөө, харин ашиглаж байгаа газарт бетон зам талбай, явган хүний зам, хашааг барьж тохижуулсан.

- *Үйлдвэрийн талбайн хэмжээнд олон салаа зам гаргахгүй байх, элс ачсан автомашиныг хучиж элсний тоос салхинд хийсээж, агаар орчинд тархахаас урьдчилан сэргийлэх.*





Үйлдвэрийн ерөнхий төлөвлөлтөнд хамгийн хөдөлгөөн ихтэй хэсгийг үйлдвэрийн төв хаалганд ойрхон байршуулах, талбайг нэг талаас нь үргэлжлүүлэн ашиглах байдлаар төлөвлөсөн. Гол идэвхтэй хөдөлгөөнийг төв хаалганд ойрхон байршуулсанаар машин бага талбайд богино замын хөдөлгөөн хийснээр цаг хугацаа болон эдийн засгийг тодорхой хэмжээгээр хэмнэх боломжтой. Мөн бусад газрын хөрсийг гэмтээхгүй байх давуу талтай. Үйлдвэрийн түүхий эд болох цемент нь зориулалтын техникт бүрэн битүүмжлэлтэй тээвэрлэгдэн ирж цементийн нөөцийн сав силост насосоор шахан шилжүүлдэг. Элс, хайрга дайргыг трак машинаар зөөвөрлөдөг ба ачааны дээгүүр зориулалтын хучлагаар хучин, стандартад заасан хэмжээгээр ачиж тээвэрлэдэг.

Хорт хийг бууруулах арга хэмжээ, түүний гүйцэтгэл:

- *Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтанд тогтмол оруулж, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх, кови, автосамосвалын янданд оч баригч хийж ажиллах нь ялангуяа хуурайшилт ихтэй хаврын улиралд гал гарахгүй байх нөхцөлийг хангах гол үзүүлэлт юм.*

Үйлдвэрийн нийт 10 миксер, 1 трак, 2 помп, 1 чиргүүл, 1 ковш, үйлчилгээний зориулалттай 1 суудлын машин нийт 16 тээврийн хэрэгслийг техникийн үзлэг шалгалтанд оруулж, засвар үйлчилгээг бүрэн хийсэн.

Хөрсөнд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ, гүйцэтгэл:

- *Үйлдвэрийн талбайн хэмжээнд барилга байгууламж барих үед ухагдаж эвдэгдэх талбайн гадаргын өнгөн хөрсийг стандартын дагуу 20-30см зузаантай хуулан авч, тусгай газарт овоолон байршуулах, хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах.*

*Налайх дүүргийн авто замын ажил дууссаны дараа нөхөн сэргээлтээр газрын гадаргуугийн өнгөн хэсгийг аль болох анхдагч төрх байдалд нь ойртуулан засч тэгшлэх, хэлбэршүүлэх.*

Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн объектод ямар нэгэн барилга байгууламж баригдаагүй байна. Цаашид бүтээн байгуулалтын ажил хийгдэх үед тухайн жилийн менежемент төлөвлөгөөндөө тусган, нөхөн сэргээлтийн арга хэмжээг авч ажиллах болно.

- *Машины олон салаа зам гаргахаас сэргийлэх, гол замыг засч тохижуулах, тэмдэгжүүлэх.*

Үйлдвэрийн ерөнхий төлөвлөлтөнд хамгийн хөдөлгөөн ихтэй хэсгийг үйлдвэрийн төв хаалганд ойрхон байршуулах, талбайг нэг талаас нь эхлэн ашиглах байдлаар төлөвлөсөн. Гол идэвхтэй хөдөлгөөнтэй хэсгийг төв хаалганд ойрхон байршуулсанаар машинууд бага талбайдбогино замын хөдөлгөөн хийснээр цаг хугацаа болон эдийн засгийг тодорхой хэмжээгээр хэмнэх боломжтой. Мөн бусад газрын хөрсийг бага гэмтээх давуу талтай.

- *Салхи ихтэй болон автомашины хөдөлгөөн ихтэй үед тоосжилт дарах арга хэмжээ авах.*

Манай үйлдвэрийн гол зорчих хэсэг нь бетондсон зам тул тоосжилт харьцангуй бага. Цаг агаараас шалтгаалсан салхи ихтэй, хавар болон намрын улиралд хуурай тоосжилт ихсэх үед шаардлагатай зам талбайг усалж тоосжилтыг багасгадаг.

- *Зарим шаардлагатай онцгой бүсэд тэмдэг тэмдэглэгээг тогтоон тэмдэгжүүлэх, анхааруулга санамж хийж тавих, цахилгаан гэрэл, дохиоллын системтэй болгох.*

Үйлдвэр баазын онцгой цэгүүдэд гэрэлтүүлэг болон хяналтын камерыг байршуулан Харуул хамгаалалтын алба 24 цагийн турш хянан ажилладаг ба энэ нь үйлдвэрийн ажилчид шөнө оройн цагаар хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, мөн ажиллах үеийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангадаг. Тодорхой цэгүүдэд үйлдвэрийн ажилчдад зориулсан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зурагт самбар, санамж, тэмдэг тэмдэглэгээнүүд, дуут дохиог тус тус байршуулсан.









2022 онд үйлдвэр бааз дээр харуулын 2-р пост болон ажилчдын саравч шинээр барьсан.



Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж, гүйцэтгэл:

- *Унд ахуйн хэрэгцээнд усыг зөөлрүүлж, цэвэршүүлэн хэрэглэх.*

Тус үйлдвэр нь 120 метрийн гүнээс 1.4л/сек-ийн ундарга бүхий гүний худаг гарган үйлдвэрлэл болон унд ахуйн усны хэрэгцээгээ хангадаг. 2013 оны усны шинжилгээний хариунд усыг ахуйн хэрэглээнд хэрэглэх боломжтой гэж гарсан.

- *Үйлдвэрийн болон ахуйн хог, хаягдал ус нь газрын гадаргын болон газрын доорх усыг бохирдуулахаас сэргийлэх, бохирын цооногийг стандартын дагуу доторлох, бохир усыг цэвэрлэх, зайлуулах байгууламжийг холбогдох горим журмын дагуу байгуулах.*  
*Усны нөөцийг зөв зохистой, хэмнэлттэй ашиглах техник технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлэх, техник тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэсэн усыг бүтээгдэхүүн үйлдвэрлэлд эргүүлэн ашиглах цэвэрлэх байгууламжийг барьж ашиглалтанд оруулах.*  
 Үйлдвэр баазын ахуйн усны бохир болон бие бие засах газрын бохир нь нэг цэгт төвлөрдөг. Стандартын дагуу бохирын цооногийн хана, шалыг бүрэн доторлосон. Бохирын цооног дүүрсэн тохиолдолд тусгай зориулалтын техникээр бохирыг соруулж тээвэрлэхээр төлөвлөсөн. Цаашид үйлдвэрийн шингэн хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй, усыг тодорхой түвшинд шүүн тунгааж, дахин ашиглах байдлаар шийдвэрлэсэн ус цэвэршүүлэх цооногийг барьж ашиглахаар судалгааны ажлыг ирэх оноос хийхээр төлөвлөж байгаа.
- *“Усны тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 30.1.2-т заасны дагуу үйлдвэрийн гүний худагт Монгол улсад хэрэглэхийг зөвшөөрсөн, Хэмжилзүйн төв байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурыг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан усны эх үүсвэрт суурилуулах.*
- Хэмжилзүйн төв байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурыг усны эх үүсвэрт суурилуулсан ба тоолуурын заалтыг үндэслэн харъяа дүүргийн татварын албанд ус ашигласны төлбөрийг төлсөн.

### СХЗГазрын баталгаажуулалтын гэрчилгээ

Наименование неисправности	Возможная причина	Метод устранения
1 Вода не проходит через счетчик	Засорился фильтр	Демонтировать счетчик, снять фильтр, почистить и промыть его
2 Вода проходит через счетчик, в сигнальная звездочка счетного механизма неподвижна или вращается медленно или рывками	Наличие твердого остатка на магните крыльчатки  Неисправность счетного механизма	Снять счетный механизм, открыть проточную камеру крыльчатого модуля, почистить и промыть магнит крыльчатки  Заменить счетчик

3.4.2 Устранение неисправностей производится в мастерской с последующим предъявлением счетчика на поверку или калибрование.

4 ТРАНСПОРТИРОВАНИЕ И ХРАНЕНИЕ

Счетчик в упаковке изготовителя может транспортироваться всеми видами закрытого транспорта в соответствии с правилами перевозки грузов, действующими на каждом из видов транспорта.

4.2 Условия транспортирования:  
 - температура окружающего воздуха от минус 50°C до 50°C;  
 - относительная влажность до 95 % при температуре 35 °C.

4.3 При погрузочных работах и транспортировании необходимо соблюдать требования манипуляционных знаков на упаковке. Счетчик в упаковке не должен попадать под атмосферные осадки.

4.4 Счетчик должен храниться в упаковке изготовителя при температуре окружающего воздуха от 5°C до 50°C и относительной влажности до 80 % при температуре 35 °C.

5 УТИЛИЗАЦИЯ

Счетчик, отработавший срок службы или не подлежащий применению по другим причинам, подлежит разборке с целью переработки латунных деталей. Сведения про содержание цветных металлов приведены в Приложении А.

6 ГАРАНТИИ ИЗГОТВИТЕЛЯ

6.1 Гарантийный срок хранения счетчика – 18 месяцев со дня изготовления предприятием-изготовителем.

6.2 Гарантийный срок эксплуатации счетчика 24 месяца со дня введения его в эксплуатацию.

6.3 Указанные сроки эксплуатации и хранения действительны при соблюдении потребителем требований этого РЭ.

Адрес организации, выполняющей гарантийный ремонт:  
 Mongolia, Ulanbaatar city  
 Bayangol district,  
 Auto Plaza-2-8819-3966  
 Mobile: 94994455  
 Fax/Tel: 976-70163966  
 e-mail: e\_tulkhuur@yahoo.com

7 СВИДЕТЕЛЬСТВО О ПРИЕМКЕ

Счетчик воды крыльчатый ЛК-25Х МБФИ.407262.000  
 № 900031

изготовлен и принят в соответствии с ТУ У 33.2-22987900-012-2003, и признан годным для эксплуатации.  
 Сертификат утверждения типа средств измерений №387

Оператор \_\_\_\_\_ Государственный поверитель \_\_\_\_\_  
 личная подпись \_\_\_\_\_ клеймо \_\_\_\_\_

Представитель ОТК \_\_\_\_\_  
 191101  
 год/месяц/число

Приложение Б (обязательное)  
 Форма корешка талона

ОРЕНОК ТАЛОНА № \_\_\_\_\_ на гарантийный ремонт счетчика ЛК-25Х. Исполнитель \_\_\_\_\_ Ф.И.О.И.В. № \_\_\_\_\_ дата 20 \_\_\_\_\_ г.

Изготовитель: ГП "НОВАТОР"  
 Украина, 29016, г. Хмельницкий, ул. Тернопольская, 17  
 ТАЛОН № 201543  
 на гарантийный ремонт счетчика ЛК-25Х Заводской № 900031  
 ЭЛЕКТРОН ТАЛУУР ХХК

Продан магазином \_\_\_\_\_  
 Дата продажи 20 04.04.2020  
 Штамп магазина \_\_\_\_\_  
 Владелец и его адрес \_\_\_\_\_  
 подпись \_\_\_\_\_

Выполненные работы по устранению неисправностей \_\_\_\_\_



Гүний худгийн усны баталгаажсан тоолуур

/2021.10.26-ний өдрийн заалт 3,918м<sup>3</sup>/



Гүний худгийн усны баталгаажсан тоолуур

/2022.09.23-ний өдрийн заалт-5714м<sup>3</sup>/





Стандарт, Хэмжил Зүйн Газрын баталгаажуулалтын гэрчилгээ



### СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

#### УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ **00209831**

*Рокмон ХХК* .....-Д  
(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа ..... *ЛК-25Х* ..... загварын ..... *3.5 м³/ч* .....  
хэмжих хязгаартай, ...25... мм-ийн голчтой № 900031 .....-ЫН  
халуун, хүйтэн усны тоолуурыг № 015 ..... лацаар битүүмжилж  
(доогуур зурах)

..... *2023* ..... оны ..... *04* ..... -р сарын ..... *08* ..... -ны өдөр хүртэл улсын  
 баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: ..... *01313* ..... м³

*Лабораторийн тэмдэг* .....  
Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

..... *2021* ..... оны ..... *04* ..... -р сарын ..... *08* ..... -ны өдөр

2022 онд хэрэглэсэн усны хэмжээ: 1796 м.куб





Хонхор үйлдвэр баазын гүний худгийн харагдах байдал

- “Усны тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.11 дэх заалтуудын дагуу усан орчин ашиглах дүгнэлтийг Туул голын сав газрын захиргаагаар гаргуулах, уг дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчин, ногоон хөгжлийн газраас ус ашиглах зөвшөөрлийг авч ажиллах.

Ус ашиглуулах дүгнэлт





1

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА  
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2019 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 6.6

Улаанбаатар хот  
Утас: 7000-3714, 7000-3716

**1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар**  
“Рокмон” ХХК, ерөнхий захирал Б.Туул, утас 325333, факс 331343, Борлуулалтын албаны дарга  
Ж.Тамир, утас 98091187, компанийн улсын бүртгэлийн дугаар 90111245080, Регистрийн дугаар.  
2078228.

**2. Төслийн нэр, байршил**

“Рокмон” ХХК-ийн бетон зуурмагийн 1-р үйлдвэр нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны  
нутагт “Ремикон” ХК-ийн зүүн талд, 2-р үйлдвэр нь Баянзүрх дүүргийн 11-р хороо, Хонхор  
станцын хойд талд Налайхын замд байрладаг.

**3. Төсөл хэрэгжүүлэгч “Рокмон” ХХК.**

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/**

Барилга хот байгуулалтын яамнаас 2017 онд олгосон БМУ 013/17 тоот тусгай зөвшөөрлөөр үйл  
ажиллагаа явуулж байна.

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт**

M150-M500 маркийн барилгын бетон зуурмаг, төмөр бетон хийц, эдлэл үйлдвэрлэж барилгын  
талбайд тээвэрлэх, бетон зуурмаг шахагч насост машинаар үйлчлэх үйл ажиллагаа явуулдаг.

**6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/**

Үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал 150 м³/цаг, жилд 200'000 м³ бетон зуурмаг үйлдвэрлэнэ.  
Хоногт 1 ээлжээр 8-12 цаг, 8 сарын хугацаанд дунджаар 176 хоног ажилладаг. Үйлдвэрлэлийн  
үйл ажиллагаа барилгын ажлын явц, захиалга, эрэлтээс хамаарч жигд биш байдаг.

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ**

2018 онд 2 үйлдвэр нийт 14'000 м³ M100-M550 маркийн бетон зуурмаг үйлдвэрлэсэн. 2019 онд  
11'563 м³ бетон зуурмаг үйлдвэрлэхээр төлөвлөсөн.

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/**

Хонхор дахь үйлдвэрт ус хангамжийн зориулалтаар гаргасан 120 м гүн, 1.2 л/сек ашиглалтын  
ундаргатай худгаас 100 м³/хон ус авч ашиглах боломжтой. Худгийн улсын бүртгэлийн дугаар  
11000-13000-13090-0106.

Сонголон дахь үйлдвэрт ус хангамжийн зориулалтаар гаргасан 35 м гүн, 1.0 л/сек  
ашиглалтын ундаргатай худгаас 80 м³/хон ус авч ашиглах боломжтой. Худгийн улсын  
бүртгэлийн дугаар 19-5-00178.

**9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/  
Үйлдвэрийн ус хангамжийн зориулалтаар гаргасан гүний худгаас өөр усны барилга байгууламж  
ашигладаггүй.**

**10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /Насосны хүчин чадал, марк/**

Сонголон дахь үйлдвэрийн худгийн технологийн шугам дээр LXSG загварын 32 мм голчтой  
1702000022 дугаартай усны тоолуурыг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр дахин  
баталгаажуулж суурилуулсан. Баталгаажуулалтын дараах тоолуурын заалт – 04220 м³.

Хонхор дахь үйлдвэрийн худгийн технологийн шугам дээр MTL загварын 40 мм голчтой  
0801000117 дугаартай усны тоолуурыг 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдөр дахин  
баталгаажуулахад дахин ашиглах боломжгүй гэсэн акт үйлдсэн. Акт үйлдэх үеийн тоолуурын  
заалт – 43003 м³. Тус тоолуурыг 2019 оны 06 дугаар 12 өдөр сольж LXSG загварын 40 мм  
голчтой 201900270 дугаартай усны тоолуурыг суурилуулсан. Суурилуултын үеийн заалт –  
000001 м³.

Бүртгэлийн дугаар .....  
ТУУЛ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГАА  
**ХУУЛБАР ҮНЭН**  
Дарга ... *У.Н.У.У.У.*  
Гарын үсэг .....  
20 19 оны 07 сарын 03 өдөр



2

- 11. Дамжуулах байгууламж /Шугам сүлжээний урт, диаметр, эх үүсвэр/**  
Бетон зуурмагийн үйлдвэр 30 м<sup>3</sup> эзлэхүүнтэй нөөцийн сантай ба 32 болон 40 мм диаметртэй ган шугам хоолойгоор үйлдвэрийн хэсэгт холбогддог.
- 12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин**  
Ажилчдын унд ахуйн хэрэглээний бохир усыг газар дор байрлуулсан төмөр санд хуримтлуулж автомашинаар зөөвөрлөн хотын бохир усны төвлөрсөн шугамд нийлүүлдэг.
- 13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар**  
Зуурмаг зөөгч машины торх цэвэрлэгээний бохир усыг хүлээн авч тунгаан ус болон хайрга элсийг ялган дахин ашиглах зориулалттай бетон доторлогоотой эргэлтийн усан санг үйлдвэр тус бүр дээр байгуулан ажиллах шаардлагатай ;
- 14. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл**  
Хонхор дахь үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг “Эх Монголын байгаль” ХХК 2013 онд гүйцэтгэж Байгаль орчин, ногоон хөгжлийн яамаар баталгаажуулсан. Тодотгол хийлгэх шаардлагатай.  
Сонсголон дахь үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг “Эх Монголын байгаль” ХХК 2016 онд нэмэлт тодотгол хийж Байгаль орчин, ногоон хөгжлийн яамаар баталгаажуулсан.
- 15. Онцгой нөхцөл**  
Хонхор дахь үйлдвэрийн машин механизмын шатах, тослох материалыг ил задгай асгах, хөрсөнд нэвчихээс сэргийлж ажиллах;
- 16. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох**  
2019 онд ашиглах усны хэмжээг тоолуурын заалтаар тооцов.  
2018 онд Хонхор дахь үйлдвэр зогсоход усны тоолуурын заалт - 40'465 м<sup>3</sup>, Усны тоолуур сольж суурилуулсанаас хойш 2019 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн заалт -00240 м<sup>3</sup>;  
2018 онд Сонсголон дахь үйлдвэр зогсоход усны тоолуурын заалт – 03199 м<sup>3</sup>,  
2019 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн заалт – 4497 м<sup>3</sup>;
- 1. Хонхор дахь үйлдвэр:** 43'003 м<sup>3</sup> - 40'465 м<sup>3</sup> = 2538 м<sup>3</sup>, 2538 м<sup>3</sup> + 240 м<sup>3</sup> = 2778 м<sup>3</sup>  
буюу хоногт дунджаар 51.4 м<sup>3</sup>  
2019 онд 51.4 м<sup>3</sup> x 176 хоног = 9'046.4 м<sup>3</sup>/жил ус ашиглана ;
- 2. Сонсголон дахь үйлдвэр:**  
2018 онд Сонсголон дахь үйлдвэр зогсоход усны тоолуурын заалт - 03199 м<sup>3</sup>,  
2019 оны 06 дугаар сарын 27-ний өдрийн заалт – 4497 м<sup>3</sup>;  
Сонсголон дахь үйлдвэр: 4'497 м<sup>3</sup> – 3'199 м<sup>3</sup> = 1'298 м<sup>3</sup> буюу хоногт дунджаар 24 м<sup>3</sup> ус ашигласан байна.  
2019 онд 24 м<sup>3</sup> x 176 хоног = 4224 м<sup>3</sup>/жил ус ашиглана.  
Нийт: 13'270.4 м<sup>3</sup>/жил буюу хоногт дунджаар 75.4 м<sup>3</sup> ус ашиглана.
- 17. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу ногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ**  
“Усны экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах” тухай 2011 оны 302 дугаар тогтоол,  
“Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх” тухай болон “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 326, 327 дугаар тогтоолуудыг үндэслэн төлбөрийн хэмжээг тооцвол:  
Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны төлбөрт:  
1 м<sup>3</sup> усны нөөц ашигласны төлбөр: 9440 төг/м<sup>3</sup> x 20% x 0,1 = 188.8 төг  
9440 төг/м<sup>3</sup> – Экологи, эдийн засгийн суурь үнэлгээ;  
20% - Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;





3

0.1 - Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

2019 онд ашиглах усны нөөцийн төлбөрийг урьдчилан тооцоход:

**Хонхор дахь үйлдвэр:**  $9'046.4 \text{ м}^3/\text{жил} \times 188.8 \text{ төг} = 1'707'960.3$  / Нэг сая долоон зуун долоон мянга есөн зуун жаран төгрөг гурван мөнгөн/ төгрөг.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг усны тоолуурын заалтаар Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

**Сонголон дахь үйлдвэр:**  $4'224 \text{ м}^3/\text{жил} \times 188.8 \text{ төг} = 797'491.2$  /Долоон зуун ерөн долоон мянга дөрвөн зуун ерөн нэгэн төгрөг хоёр мөнгөн/ төгрөг.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2-т заасны дагуу усны нөөцийн төлбөрийн орлогыг усны тоолуурын заалтаар Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ.

**18. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмж**

- Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтын дагуу Нийслэлийн Байгаль орчны газраас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах;
- Усны нөөц ашигласны төлбөр төлөхгүй үйл ажиллагаа явуулах, ус ашиглуулах дүгнэлтээр ногдуулсан төлбөрийн орлогыг хугацаанд нь төлөхгүй ус ашиглах нь Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.3 дахь заалтын дагуу ус ашиглах эрх цуцлагдах, Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэхийг анхаарч ажиллах;
- Тоолуурын заалтын баталгаа алдагдсан / хугацаа дууссан/, шугам хоолойноос салгасан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах норм”-оор тооцож ногдуулахыг анхаарах;
- Цаашид ус ашиглуулах дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан жил бүр гаргуулж байх;
- Гэрээнд зааснаас илүү ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 391 дүгээр тогтоолоор баталсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-ын дагуу шатлан өсгөх хэлбэрээр тооцохыг анхаарах;
- Сав газрын усны мэдээллийн дэд сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тайланг 2019 оны 12 дугаар сарын 15-ны дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх;

ХЯНАСАН:

УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ  
АЛБАНЫ ДАРГА

Ю. СУВДЧИМЭГ

ДУГНЭЛТ ГАРГАСАН:

УСНЫ НӨӨЦ, УС АШИГЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ  
АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.АНХБАЯР



## НБОГазартай байгуулсан ус ашиглах гэрээ

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
ГАЗРЫН ДАРГА М.НЯМБАЯР

БАТЛАВ  
"РОКМОН" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ Б.ТУУЛ

### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 10-ий өдөр

Дугаар 2022/63

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл: 7769

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2019 оны 7-р сарын 03-ны өдрийн 04/203 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Нийслэлийн Байгаль орчин, ногоон хөгжлийн газар /хуучин нэрээр/-ын даргын олгосон 2016 оны 01-р сарын 26-ны өдрийн А/05 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж **Нийслэлийн Байгаль орчны газрын** Ойн хэлтсийн Усны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Очиржанцан овогтой Тэмүүжин, Ус ашиглагчийг төлөөлж нийслэлийн Баянгол дүүргийн 2-р хороо Үндсэн хуулийн гудамж 24 "Рокмон бюлдинг оффис төв"-ийн 8 давхарт 90111245080 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 2078228 регистрийн дугаартай **"Рокмон" ХХК-ийг** төлөөлж инженер Д.Өлзийбаяр нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2022 оны 1 дүгээр сарын 01-ээс нөхөн тооцож 2022 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

#### Хоёр. Гэрээний гол нөхцөл:

2.1 **Ус ашиглах зориулалт:** М150-М500 маркийн бетон зуурмаг үйлдвэрлэхэд усыг авч ашиглана.

#### 2.2 Ашиглах усны хэмжээ:

- 2.2.1 Унд- ахуй, м<sup>3</sup>/жил:.....  
2.2.2 Үйлдвэрлэл, м<sup>3</sup>/ жил:.....9046.4 м<sup>3</sup>  
2.2.3 Зүлэг талбайн усалгаа м<sup>3</sup>/ жил:.....  
2.2.4 Эмчилгээ, сувилгаа, хүн/ хоног:.....

2.3 **Усны чанар, найрлага:**Худгийн уснаас улирал тутамд дээж авч итгэмжлэгдсэн лабораторид хими багтерлогийн шинжилгээ хийлгэн стандартын шаардлага хангасан тохиолдолд усыг хэрэглэх.

#### 2.4 Усны эх үүсвэрийн:

- 2.4.1 Байршил:.....Баянзүрх дүүрэг 11-р хороо, Хонхор станцын хойд талд.....  
2.4.2 Солбицол:.....Худаг-47°48'31.5"N, 107°11'32.2"E.....  
2.4.3 Барилга байгууламж: Гүний худгаас өөр усны барилга байгууламж байхгүй.

Худгаас 32 мм голчтой, 50 метрийн урттай ган хоолойгоор 40 м<sup>3</sup> багтаамжтай усны нөөцийн сантай холбогддог. Сангаас бетон зуурмагийн хэсэгт холбогддог.

2.4.4Тоног төхөөрөмжийн нэр, марк: БНХАУ-д улсад үйлдвэрлэсэн бетон зуурмагийн узель.

2.4.5 Хүчин чадал: Үйлдвэрийн суурилагдсан хүчин чадал цагт 150 м<sup>3</sup> бетон зуурмаг үйлдвэрлэх.

#### 2.5 Хаягдал усны:

2.5.1 Стандартын шаардлага: "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 6561:2015 стандартын шаардлагыг хангасан хаягдал ус гаргах.

2.5.2 Хаях цэгийн байршил: Ажилчдын унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг газар доор байрлуулсан төмөр санд хуримтлуулдаг.

2.5.3 Солбицол: 47°48'28.26"N, 107°11'32.62"E

2.6 **Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:** Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

- 2.6.1 Жинлэгдэх бодис, кг:.....  
2.6.2 Органик бодис, кг:.....  
2.6.3 Эрдэс бодис, кг:.....  
2.6.4 Хүнд металл, кг:.....  
2.6.5 Аюултай бохирдуулах бодис, бодис, гр:.....



2.7 Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Ажилчдын унд ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг газар доор байрлуулсан төмөр санд хуримтлуулж, авто-цистернээр зөөвөрлөн УСУГ-ын өмнөд коллекторт нийлүүлдэг.

2.8 Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомстох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ: Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд усны нөөцийг хамгаалахад зарцуулах хөрөнгийн хэмжээг тусгаж хэрэгжүүлж ажиллах.

2.9 Усны тоолуурын:

2.9.1 Төрөл, нэр, дугаар:.....25 мм голчтой 900031 дугаартай.....

2.9.2 Загвар.....ЛК-25Х.....

2.9.3 Тоолуурын тоо:.....1.....

2.9.4 Суурилуулсан байгууллага, огноо:.....2021.04.08.....

2.9.5 Тоолуурын заалт:.....2022.09.23.....заалт.....5714 м<sup>3</sup>.....

2.10 Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2022 оны усны нөөц ашигласны төлбөрийг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай”, “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолын дагуу 5714 м<sup>3</sup>-ээс хойш тоолуурын заалтаар тооцож Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. 1 м<sup>3</sup> усны төлбөр 188.8 төг

2.11 Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ: .....-.....

**Гурав. Талуудын эрх, үүрэг:**

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв. Бусад:**

4.1 Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2 Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3 Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4 Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5 Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2 Аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Нийслэлийн Байгаль орчны газрын Ойн хэлтсийн усны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

О.Тэмүүжин

Хаяг: ЧД, Ц.Жигжиджавын гудамж  
Нийслэлийн Төр захиргааны 2 байр

Харилцах утас: 318003

Ус ашиглагчийг төлөөлж:

“Рокмон” ХХК-ийн инженер  
Д.Өлзийбаяр

Хаяг: Баянгол дүүрэг 2-р хороо, Үндсэн хуулийн гудамж 24 "Рокмон бүлдинг оффис төв"-ийн 8 давхарт  
Харилцах утас: 325333, 98081218



2022 оны 10-р сарын 10-ний өдрийн 63  
 дугаартай ус ашиглуулах гэрээний хавсралт

Д.д	Гэрээ байгуулсан он	Ашигласан усны хэмжээ			Усны нөөц ашигласны төлбөр /төг/	Тайлбар
		Сав газрын дүгнэлтээр /м <sup>3</sup> /	Тоолуурын заалтаар /м <sup>3</sup> /			
			Жилийн эхэнд	Жилийн сүүлд		
1.	2020	9046.4	00000	01313	269,229.00 төгрөг тушаасан	2020 онд 2020/18 дугаартай ус ашиглах гэрээ байгуулсан
2.	2021	9046.4	01313	03918	2605 м <sup>3</sup> Ус ашиглаж 491,824.00 төгрөгний төлбөр төлсөн.	2021 онд 2021/09 дугаартай ус ашиглах гэрээ байгуулсан
3.	2022	9046.4	03918			2022 онд 2022/63 дугаартай ус ашиглах гэрээ байгуулсан

- “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль” болон түүнд нийцүүлэн баталсан Монгол улсын Засгийн Газрын 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 326 дугаар бүхий “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” тогтоолын дагуу усны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөрийг төлөх.
- 2022 онд Хонхор дахь бетон зуурмагийн үйлдвэр бааз нь 1796м<sup>3</sup> ус ашигласан болно.
- Бохирын цооног гаргах.  
Цайны газар болон угаалгын өрөөнөөс гарах ахуйн хэрэглээний усны бохирын хоолой нь гадаа жорлонтой газар доогуур бохирын шугамаар холбогдсон. Бохирын цооногийн шал болон ханыг битүү доторлон, дүүрсэн үед соруулан зөөж хаях байдлаар төлөвлөгдсөн.



- Хатуу хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

Хонхор, Сонсголон үйлдвэр баазын ахуйн болон хатуу хог хаягдлыг Сонгинохайрхан дүүргийн Улаан Чулуутын барилгын хог хаягдлын цэгрүү өөрсдийн машин техникээр тээвэрлэдэг.


## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Бетон зуурмагийн үйлдвэр нь компьютер удирдлагатай, технологи арга ажиллагаа нь бүрэн автомат юм.

Үйлдвэрлэлийн технологи нь **түүхий эдийг хүлээн авах - хадгалах - зөөвөрлөх - хэмжих - бетон зуурмаг бэлтгэх - хэрэглэгчдэд нийлүүлэх** гэсэн үндсэн технологийн дарааллаар явагдана.

Үйлдвэрлэлийн технологи схем





## **Түүхий эдийг хүлээн авах, хадгалах**

Түүхий эдийг дагалдах чанарын гэрчилгээ болон бусад баримт бичигт заасан хэсгийн дугаар, хэмжээ, чанарын үзүүлэлтүүд тохирч байгаа эсэхийг гадна байдлаар нь магадлан шалгасны дараа шаардлага хангаж байна гэж үзвэл тус бүрийн агуулахад хүлээн авна. Дүүргэгч материалыг тусгайлан бэлдсэн талбайд ширхэглэлээр нь ангилан овоолж ил хадгална.

Цементийг тус бүр нь 200 тн-н багтаамжтай 4 ширхэг зориулалтын силосонд хадгалдаг. Цементийн силос нь бүрэн битүүмжлэгдсэн байдаг тул доторх цементийн хэмжээг мэдрэх дохиоллын системтэй.

Бетон зуурмагт ашигладаг нэмэлт бодисыг 4 тоннын багтаамжтай цилиндр саванд нөөцлөн, үйлдвэрлэлийн явцад цилиндр савнаас шууд татуулан хэрэглэнэ.. Завсрын нөөцийн саван дахь нэмэлт бодисын хэмжээ багасахад дахин татуулж цэнэглэнэ.

Үйлдвэрлэлд хэрэглэх усыг тус бүр нь 50 тонн багтаамжтай дотор талыг нь зэврэлтээс хамгаалагдсан 2 ёмкост саванд нөөцөлдөг.

## **Түүхий эдийг зөөвөрлөх**

Дүүргэгч материал болох элс, дайргыг тус тусад нь ээлжлэн ковш машинаар хутган хүлээн авагч бункерт хийнэ.

Цементийг налуу шурган дамжуулагчаар зөөвөрлөн тугнаад зуурах хэсэгт өгнө.

Усыг төмөр хоолойгоор насосоор шахаж 1000 литрийн багтаамжтай завсрын нөөцийн саванд өгнө.

Химийн нэмэлтийг нарийн pvs хоолойгоор насосаар шахаж 400л багтаамжтай завсрын саванд өгсний дараа тугнаад зуурах хэсэгт өгнө.

Завсрын бункерүүд нь доторх материалын хэмжээ багасаж байгааг хянан операторт мэдээлэх дохиоллын системээр дохио өгнө.

## **Түүхий эдийг хэмжих**

Түүхий эдийг зориулалтын хэмжих хэрэгсэл болох автомат DKIE 9000 (9009) маркийн хэмжих тугнуураар жингийн аргаар хэмжинэ.

Ус буюу шингэн нэмэлтийг эзэлхүүний аргаар хэмжинэ.

Дээрх хэмжих хэрэгсэл тугнуурын үнэн зөв ажиллагааг тогтмол хянахын тул жил бүр тогтмол Улсын Хэмжил Зүйн албаар шалгуулж баталгаажуулдаг.

## **Бетоны найрлагыг тогтооох, хянах**

Манай бетон зуурмагийн үйлдвэрийн төхөөрөмж нь түүхий эдүүдийг хувь хэмжээгээр нарийн хэмждэг бүрэн автомат систем бүхий удирдлагын операторын өрөөтэй. Зуурмагийг төхөөрөмжөөр хольж зуурах үед оператор компьютерийн системийн дэлгэц дээр явагдаж буй процессыг бүрэн хянадаг. Хэрэв ямар нэг материалын орцын хэмжээ ба масс, түүнийг оруулах хугацаа зэрэгт өөрчлөлт оруулах шаардлагатай бол компьютерийн системийн удирдлагын тусламжтайгаар тохируулах боломжтой. Бетоны найрлага, бат бөх, марк нь түүний дүүргэгч материал /элс, дайрга/-ын тоосжилт, ширхэглэл ба түүний модуль, элсэнд агуулагдах хайрга, тэдгээрийн орцын хэмжээ, цементийн марк, ус-цементийн харьцаа, цаашилбал шингэрүүлэгч химийн нэмэлт бодисын орцын хэмжээ зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Иймд бид Барилга архитектур корпорацийн Барилгын материал, технологийн судалгааны төвийн Бетон дүүргэгчийн итгэмжлэгдсэн лабораторид өөрийн бүтээгдэхүүндээ бетоны найрлагын шинжилгээг тогтмол хийлгэн баталгаажуулдаг.

### **Бетон зуурмаг зуурах**

Бетон зуурмагийг хэвтээ хоёр голт, албадмал ажиллагаатай,  $2.5\text{м}^3$  багтаамжтай зуурагчаар зуурна. Нэг удаагийн зууралтанд тохируулан хэмжсэн түүхий эд, материалаа хуурай хольц /Дайрга, элс, цемент/ + ус + нэмэлт гэсэн дарааллаар зуурагчид хийж нэг минутын хугацаатай зуурна. Бэлэн болсон зуурмагийг цоргоор дамжуулан тээврийн хэрэгсэлд /миксер машин/ юүлнэ. Зуурмаг зуурсанаас хойш зуурагч буюу юүлэх цоргонд зуурмагийг 5 минутаас илүү удаан хугацаагаар байлгаж болохгүй.

### **Бетон зуурмагийг тээвэрлэх**

Бетон зуурмагийг тээвэрлэхдээ бетон хольцыг нэг төрлийн байлгах, түүний хөдөлгөөнт чанарыг алдагдуулахгүй байлгах зорилгоор тээвэрлэх явцдаа зуурмагаа хутгаж явдаг зориулалтын авто хэрэгсэл /миксер машин/-ээр тээвэрлэнэ. Тэр нь зуурмагийг гадна орчноос бүрэн тусгаарлан хамгаалж, алдагдалгүй тээвэрлэх, тээвэрлэлтийн явцад суулт, үелэлт үүсгэхгүй, зуурмагийн найрлагад өөрчлөлт оруулахгүй байх зориулалтын технологийн төхөөрөмж юм. Тээвэрлэлтийн үеийн бетон зуурмагийн технологийн шинж чанарт хадгалалтыг удаашруулах зорилгоор уян налархайжуулагч барьцалдуулах хугацааг удаашруулагч нэмэлт бодис хэрэглэдэг.

### **Үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, түүхий эд, бүтээгдэхүүний чанарын хяналт**

Түүхий эд болон бүтээгдэхүүний чанарын шалгалтыг өөрийн лабораторид болон итгэмжлэгдсэн лабораторитой хамтран гүйцэтгэдэг. Үүнд:

- Бетон сорьцын бат бэхийг 28 хоног тутамд,
- Түүхий эдийн шинжилгээг улиралд 1 удаа,
- Түүхий эдийн орд өөрчлөгдсөн бол тухай бүрт орцын нормыг тодорхойлуулж шинэчлэнэ.
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан илэрч болзошгүй зөрчил, тэдгээрийг арилгах ажлыг үйлдвэрлэл эрхэлсэн инженер, техникийн ажилтнууд шууд хариуцан зохион байгуулна. Манай үйлдвэр нь өөрийн дотоодын лабораторитой бөгөөд 7 хоног бүр түүхий эдийн шинжилгээ, бетон зуурмагийн сорьц авч чанарын хяналтыг 7, 14, 28 хоног тутамд хийдэг.

Түүхий эдийн шинжилгээний хариуг

Хавсралт 01-т оруулав

**Түүхий эд, туслах материал, эцсийн бүтээгдэхүүн**

Бетон зуурмагийн үйлдвэрлэлд үнэдсэн түүхий эдүүдээр элс, дайрга, цемент, нэмэлт, ус хэрэглэгдэнэ. Том болон жижиг дүүргэгч материалаар 0,5мм-ийн элсийг “Мерсу” ХХК-с, 10-20мм-ийн дайргыг “ЦээЦээ импекс”ХХК-аас гэрээний дагуу худалдан авах ба 4.25МПа-аас багагүй маркийн портланд цементийг “Мөнхийн Баян Гал” ХХК-иудаас гэрээний дагуу тээвэрлэн авч бетон зуурмагтаа ашиглаж байна. Химийн нэмэлт бодисыг “Талын торгон зам” ХХК-ны MZ01 зуны уян налархайжуулагч, усны орц багасгадаг химийн нэмэлт хэрэглэж байна.

2022 оны үйлдвэрт хэрэглэгдсэн түүхий эдийн хэмжээ ба усны зарцуулалтын тооцоо

Марк	Мулт	M100	M150	M200	M250	M300	M350	Нийт	
Орц	Хайрга 10-20		780	800	810	830	820	830	
	Элс	1750	1200	1150	1120	1080	1060	1040	
	Цемент	400	230	260	280	320	360	395	
	нэмэлт /pc2/					3.2	3.6	3.9	
	Ус/литр		220	220	215	210	205	200	
<b>Үйлдвэрлэсэн хэмжээ</b>	<b>17</b>	<b>18</b>	<b>251</b>	<b>412</b>	<b>1,187.50</b>	<b>1029</b>	<b>342</b>	<b>3,256.50</b>	
Зарцуулалт	Хайрга 10-20	-	10.03	143.43	238.37	704.02	602.70	202.76	<b>1,901.30</b>
	Элс	18.59	13.50	180.41	288.40	801.56	681.71	222.30	<b>2,206.48</b>
	Цемент	6.80	4.14	65.26	115.36	380.00	370.44	135.09	<b>1,077.09</b>
	нэмэлт /pc2/	-	-	-	-	3,800.00	3,704.40	1,333.80	<b>8,838.20</b>
	Ус/литр	-	3,960.00	55,220.00	88,580.00	249,375.00	210,945.00	68,400.00	<b>676,480.00</b>
	Ус							<b>676.48</b>	<b>676.48</b>
	Бусад зарцуулалт							<b>1,120.00</b>	<b>1,120.00</b>
	Нийт							<b>1,796.48</b>	<b>1,796.48</b>

“Рокмон” ХХК-ний Хонхор дахь бетон зуурмагийн үйлдвэр бааз нь 2022 онд нийт 3256,5 м.куб бетон зуурмаг үйлдвэрлэсэн.

**Үйлдвэрийн усны хэрэглээний тооцоо**

“Рокмон” ХХК-ний Хонхор дахь бетон зуурмагийн үйлдвэр нь 2022 онд усны тоолуурын заалтаар нийтдээ 1796 м.куб ус хэрэглэсэн байна. Бетон зуурмагт 676 м.куб ус хэрэглэсэн. Үйлдвэрийн тоосжилтыг бууруулах зорилгоор зам талбайг тогтмол усалсан. Мөн мод, зүлэг, гал тогоо, машин техникийн цэвэрлэгээнд 1120 м.куб ус хэрэглэсэн байна.

Нийт-**339085** төгрөгийн төлбөрийг Баянзүрх дүүргийн Татварын хэлтэст төлсөн болно.



